# БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 09 өдөр Дугаар А/07 Улаанбаатар хот

## Гамшгаас хамгаалах төлөвлөгөө тухай

Монгол улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахтай холбогдуулан нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахыг Төслийн менежер /Г.Пүрэвсүрэн/-т үүрэг болгосугай.
3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шаардлагатай төсвийг тухай цаг бүрт холбогдох зардлаас гаргахыг Нягтлан бодогч /Ц.Мөнхдөл/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТ
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
6046231 1116117863

ДАРГА Н.УУГАНБАЯР

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

# ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

12

БАТЛАВ.

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ”

ОНӨТҮГ-ЫН ДАРГА /Н.УУГАНБАЯР/

УЛААНБААТАР ХОТ БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ УТҮГ 6082231 1116117863

# “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР ........................................ Г.ПҮРЭВСҮРЭН

| | | | |
|---|---|---|---|
| Тодотгосон: | он | сар | өдөр |
| | он | сар | өдөр |
| | он | сар | өдөр |

2021 он

# ГАРЧИГ

1. Төлөвлөгөөнд тодотгол хийсэн тэмдэглэл
2. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж”ОНӨТҮГ-ын танилцуулга
3. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб томилсон тухай тушаал, хавсралтууд
4. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, штабын дарга чиглэл хариуцсан туслахуудын үүрэг
5. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
6. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө 2021
7. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүтэц, бүрэлдхүүн, хүч, хэрэгсэл, ажилтнуудын гэрийн хаяг, утасны жагсаалт
8. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах схем
9. Гамшгийн үеийн үйл ажиллагааны үүрэг хариуцлагын хуваарилалт
10. Гамшгаас хамгаалах арга хэмжээ
11. Мэдээлэл харилцаа холбооны албаны бүрэлдхүүн
12. Радио холбооны ангийг томилсон тухай тушаал, хавсралт
13. Гамшгаас хамгаалах бэлэн байдалд шилжүүлэх арга хэмжээний график төлөвлөгөө
14. Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын Гал усны гамшгийн үед цуглах схем
15. Байр талбай хамтран эзэмшиж байгаа үед ХАБЭА, ГАБ-ыг хангах журам
16. Галын аюулгүй байдлыг хариуцах албан тушаалтан, хүлээх эрх, үүргийн хуваарь
17. Байранд гал гарсан үед ажиллах ерөнхий дэг
18. Гражид гал гарсан үед ажиллах дэг
19. Галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж
20. Дарга захирлын шийдвэр
21. Аюулгүй талбайн байрлал
22. Байгууллагын план зураг
23. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцсан тухай хүснэгт

## “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” – ОНӨТҮГ-ЫН ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн 10 жилд хот орчмын малын тоо толгой өсөн нэмэгдсэн хэдий ч хотын хүн амын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа нь нийслэл орчимд эрчимжсэн мал аж ахуйг цогцоор хөгжүүлэх, малын ашиг шимийг дээшлүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах болон тэжээлийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1-д “Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангах” зорилтыг тусгасан боловч энэхүү заалтын биелэлт төдийлөн хангалттай биш байсан. Иймээс Нийслэлийн Засаг дарга Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 б заалтад заасан өөрийн нийтлэг бүрэн эрхийн хүрээнд “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг өргөн барьж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоолоор батлуулсан.
“Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөр нь Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр Монгол орны хөрс, цаг уурын нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй, тэжээлийн олон наст ургамлыг тарималжуулан нутагшуулах замаар тэжээлийн чанарыг сайжруулах, нэг үнээнээс саалийн хугацаанд авах сүүний гарцыг нэмэгдүүлэх зорилготой. Австри улсаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хөтөлбөр хэрэгжүүлэх баг нь 23 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах шаардлагатай учир урсгал зардлыг хэмнэх зорилгоор хөтөлбөрийг хэрэгжүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн Газарт даалгаж, ажлын хэсгийг батлах тухай Нийслэлийн Засаг даргын 2015 оны 190 дүгээр захирамж гарсан.

Энэхүү хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд :

1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах шинэ технологийг нэвтрүүлснээр бэлчээрийн талхагдлыг багасгаж, цөлжилтийг бууруулна.
2. Тэжээлийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг 2-3 дахин ихэсгэх боломж бүрдэнэ.
3. Дээрхи шинэ технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өвөл, хаврын улиралд ч шимт чанарыг алдагдуулахгүйгээр малаа тэжээх боломж бүрдэнэ.
4. Туршилтын талбай, тэжээл, сүүний гарцын судалгаа болон сургалт, засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулна.
5. Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах ба үүний үр дүнд “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй”-д тулгуурлан практик байдлаар дээрхи дэвшилтэт технологиудыг

танилцуулах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, бодитоор хэрэгжүүлнэ.

6. Нэг монгол үнээнээс саалийн хугацаанд авах сүүний гарц 2000 л байдаг бол нэгж талбайгаас авах ногоон массын ургац болон тэжээлийн шимт чанарыг сайжруулснаар сүүний гарцыг 2 дахин нэмэгдүүлэх зэрэг болно.

Хөтөлбөрийг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Нарийний хөндийн Өвөр шар хоолойн аманд хэрэгжүүлж, сонгогдсон газрын байгалийн бэлчээрт тэжээлийн олон настын шинэ сорт, таримлуудыг тарьж нутагшуулан, ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэн тариалах, сургалтын болон засварын төв бүхий загвар аж ахуйг байгуулахаар төлөвлөсөн. Тухайн үеийн НҮХААГазраас тухайн төслийн хүрээнд хийх ажлыг гүйцэтгэх компаниудийг тендер зарлан шалгаруулсан. Үүнд :

- бэлчээрийн талбайн 150 га газрыг хашаалсан, худаг 2 ширхэг гаргасан
- Эрчимжсэн мал аж ахуйн жишиг аж ахуй, сургалтын төвийн барилга .
- Дунд оврын техник тоног төхөөрөмжүүд..
- Бага оврын техникүүд.

Нийслэлийн засаг даргын “Суурьшлын бүсээс мал амьтныг гаргах, зөвшөөрсөн бүс нутаг руу нүүлгэн шилжүүлэх” захирамжийн дагуу 30 тугалтай үнээ сонгон авч фермдээ шилжүүлсэн. Австри улсын Раумберг- Гүмпенштайны Институтийн Газар тариалан болон хөрс судлалын тэнхимийн дарга Др. К.Бухграбер болон Австри-Монголын бизнесийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн дарга Др.Ф.Грайф нартай хамтарч ажиллан, тэдний олон жилийн судалгааны үр дүнг монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд туршиж Австри улсын шинэ сорт, таримлуудыг тарималжуулах, Хятадын тэжээлийн олон наст холимогыг харьцуулан судлах ажлыг хийж байна.

Мөн Сонгинохайрхан дүүргийн Нарийны хөндийн “Шар хоолойн ам” –ны 500 га газрыг орон нутгийн хэрэгцээнд авч, 150 га туршилтын талбай, сургалтын төв болон 90 үхрийн жишиг аж ахуйг байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/493 тоот захирамжаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж – ОНӨТҮГ-ын бүтэц орон тоог доорхи байдлаар баталсан. Үүнд:

1. Газрын дарга
2. Нягтлан бодогч
3. Төслийн менежер, орчуулагч
4. Агрономч
5. Мэргэжилтэн, туслах
6. Сургагч багш оператор
7. Нярав, талбайн зохион байгуулагч
8. Тоног төхөөрөмжийн оператор
9. Манаач, туслах малчин

10. Жолооч зэрэг болно.

"Бэлчээрийн менежмент төслийн нэгж"-ОНӨТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдах бөгөөд даргыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

**Байгууллагын зорилго:** Үйл ажиллагааны үндсэн зорилго нь "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулахад оршино.

**Байгууллагын зорилт:**

1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах БНАУ-ын дэвшилтэт шинэ технологийг турших нэвтрүүлэх.
2. Дээрх технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.
3. Тэжээлийн ургамлын бүтэц бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх
4. *Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх.*
5. *Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий "Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах.*
6. *Малчид фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрх дэвшилтэт технологийг малчид фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх зэрэг болно.*

**Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/282 тоот захирамжаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж – ОНӨТҮГ-ын бүтэц орон тоог шинэчлэн баталсан.**

Батлагдсан шинэ бүтцээр Дарга, Төслийн менежер, Нягтлан бодогч, Агрономч, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн, Механик инженер, Нярав, Тоног төхөөрөмжийн оператор, Фермер, Манаач гэсэн орон тоон дээр 10 хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

| | |
|---|---|
| 1. Газрын дарга | Нармандахын Уганбаяр |
| 2. Төслийн менежер | Гомбосүрэнгийн Пүрэвсүрэн |
| 3. Нягтлан бодогч | Цэдэнбалын Мөнхдөл |
| 4. Агрономч | Бүүвэйгийн Баярцэцэг |
| 5. Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн | Адъяасүрэнгийн Гэрэлтуяа |

6. Механик инженер — Мөнхбатын Бат-Эрдэнэ
7. Нярав — Баярцогтын Дорждэрэм
8. Тоног төхөөрөмжийн оператор
9. Фермер — Ганболдын Туул
10. Манаач — Алтанцэцэгийн Баярсайхан нар болно.

## БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ-ЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

| Д/д | Төлөвлөгөөг тодотгосон албан тушаалтан, овог нэр | Тодотгол хийсэн Он, сар , өдөр | Тодотгол хийсэн хуудасны дугаар | Тодотгол хийсэн товч утга |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |
| 6 | | | | |
| 7 | | | | |
| 8 | | | | |
| 9 | | | | |
| 10 | | | | |
| 11 | | | | |
| 12 | | | | |
| 13 | | | | |
| 14 | | | | |
| 15 | | | | |

# “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны ...... сарын . .өдөр дугаар . .. .. Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн анги томилох тухай

Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүний нэрсийг хавсралт 1-р, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралт 2-р тус тус батлалсугай.

2. Штаб, мэргэжлийн ангийн бүрэлдхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, шаардлагатай нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болон үүрэг гүйцэтгэх багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах ажлыг штабын дарга /Г.Пүрэвсүрэн/ -д үүрэг болгосугай.

3. Штаб, мэргэжлийн ангийн гишүүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, үүрэг гүйцэтгэх багаж хэрэгслээр хангах, гамшгаас хамгаалах ангиллын сургалт явуулахад шаардагдах зардлыг холбогдох зардлын сангаас гарган зарцуулахыг Хангалт хариуцсан туслах /Ц.Мөнхдөл/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Н.УУГАНБАЯР

УЛААНБААТАР ХОТ
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ
УТҮГ
6046231 1116117863

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”
ОНӨТҮГ-ын даргын 2021 оны ......сарын .......
өдрийн ... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТ БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ УТҮГ 6046231 1116117863

# ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ БУС ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭР

| Д/д | Албан тушаал | | Овог нэр | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн | Томилгоожсон | | |
| 2 | Төслийн менежер | Штабын дарга | Г.Пүрэвсүрэн | |
| 3 | Хүний нөөцийн мэргэжилтэн | Байгууллагын тогтвортой үйл ажиллагаа хариуцсан туслах | А.Гэрэлтуяа | |
| 4 | Нягтлан бодогч | Хангалт хариуцсан туслах | Ц.Мөнхдөл | |
| 5 | Механик | Сургалт мэргэжлийн анги хариуцсан туслах | М.Бат-Эрдэнэ | |
| 6 | Агрономч | Сурталчилгаа хариуцсан туслах | Б.Баярцэцэг | |
| 7 | Нярав | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хариуцсан туслах | Б.Дорждэрэм | |

УЛААНБААТАР ХОТ
МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ
6046231 1116117863

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”
ОНӨТҮГ-ын даргын 2021 оны ....... сарын .......
өдрийн ... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭР

| **Д/д** | **Албан тушаал** | | **Овог нэр** | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| 1 | **Үндсэн** | **Томилгоожсон** | | |
| | ***Нэг: Аврах бүлэг*** | | | |
| 1 | Төслийн менежер | Бүлгийн ахлагч | Г.Пүрэвсүрэн | |
| 2 | Тоног төхөөрөмжийн оператор | Аврагч | | |
| 3 | Манаач | Аврагч | А.Баярсайхан | |
| | ***Хоёр: Зөөх бүлэг*** | | | |
| 1 | Механик | Бүлгийн ахлагч | М.Бат-Эрдэнэ | |
| 2 | Нярав | Зөөгч | Б.Дорждэрэм | |
| 3 | Нягтлан бодогч | Зөөгч | Ц.Мөнхдөл | |
| | ***Гурав: Галын бүлэг*** | | | |
| 1 | Хүний нөөцийн мэргэжилтэн | Бүлгийн ахлагч | А.Гэрэлтуяа | |
| 2 | Агрономч | Журам сахиулагч | Б.Баярцэцэг | |
| 3 | Фермер | Журам сахиулагч | Г.Туул | |

# ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ БУС ШТАБ, ШТАБЫН ДАРГА ЧИГЛЭЛ ХАРИУЦСАН ТУСЛАХУУДЫН ҮҮРЭГ

Нэг. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын үүрэг

1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, мэргэжлийн байгууллагын гамшгаас хамгаалах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлнэ.
2. Байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулна.
3. Байгууллагын үйлчилгээний онцлогт зохицуулан штаб, мэргэжлийн ангийг байгуулж, гүйцэтгэх үүрэгт нь сургаж бэлтгэн, бэлэн байдлыг хангуулах, гамшигтай тэмцэх багаж хэрэгслийн дотоод нөөц бололцоог бэлтгэнэ.
4. Гамшгаас аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгахад шаардагдах бараа, материал, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.
5. Гамшгаас хамгаалах дайчилгаа явагдахад шаардлагатай техник, ажилчдыг гаргана.
6. Гамшгийн үед сургалт хүмүүжлийн тогтвортой байдлыг хангана.
7. Сургалт хүмүүжлийн онцлогт нийцүүлэн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.
8. Гамшгаас хамгаалах шаардлагыг биелүүлнэ.
9. Гамшгийн нөхцөл байдал үүсэхэд мэргэжлийн байгууллагад шуурхай мэдэгдэн аврах, хир уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг зохион байгуулна.
10. Гамшгийн үед газрын үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим хэсгийг онцгой дэглэмд шилжүүлнэ.
11. Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй харилцан ажиллагааг зохион байгуулна.

Хоёр: Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын даргын үүрэг:

1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг удирдан боловсруулж, улирал тутамд тодотгон, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.
2. Штабын дотоод ажлыг төлөвлөн зохион байгуулах, туслахуудын ажлыг уялдуулан зохицуулж, өдөр тутмын удирдлагаар хангана.
3. Гамшгаас хамгаалах талаар мэргэжлийн байгууллагын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавина.

4. Гамшгийн зарлан мэдээлэл дамжуулах дотоодын системийг зохион байгуулж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулна.
5. Гамшгийн голомтод гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангиар хор уршгийг арилгах ажлыг гүйцэтгүүлнэ.
6. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
7. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын байрлалд гамшгийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд гамшгийн голомтод ажиглалт, тандалт, үнэлгээ хий, эрэн хайх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна.

Гурав: Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан туслахын үүрэг:

1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын даргаас үүрэг авмагц холбоо зарлан мэдээлэл хийх төлөвлөгөөний дагуу ажиллаж зарлал, мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулна.
2. Сонгино хайрхан дүүргийн онцгой байдлын хэлтэс, гамшгийн үед ажиллах зарлан мэдээлэл хийх схемийн дагуу 8 албанд утсаар болон биечлэн зарлан мэдээлэл хийх төлөвлөгөөг гаргаж ажиллах
3. Цаг үеийн дараагийн шатны мэдээллийг хүлээн авахад бэлтгэн, холбогдох техник хэрэгслийг бэлтгэх ажлыг зохион байгуулна.
4. Зарлал мэдээллийн нөөц төхөөрөмжийг суурилуулах, ажиллах хүчийг бэлтгэх ажиллагаанд оруулах ажлыг зохион байгуулна.

Дөрөв: Тогтвортой ажиллагааг хариуцсан туслахын үүрэг

1. Гамшиг учирсан үед “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын хэвийн найдвартай ажиллагаанд хяналт тавьж зарлан мэдээлэл явуулах ажлыг зохион байгуулна.
2. Гамшгийн үед хэв журам сахиулах, аюулгүй байдлыг хангах эргүүл постын үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавина.
3. Ард иргэдэд болзошгүй гамшгийн талаар урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

Тав: Сургалт мэргэжлийн анги хариуцсан туслахын үүрэг

1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулна.
2. Гамшгаас хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч сургалт, дадлага зохион байгуулах ажлыг хийнэ.
3. Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах, тэдэнтэй дадлага сургууль хийх ажлыг зохион байгуулна.

4. Гамшгаас хамгаалах мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна.
5. Мэргэжлийн ангийн аврах ажлын зориулалттай багаж хэрэгслээр хангуулах ажлыг зохион байгуулна.
6. Мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж байгаа нэгдсэн сургалт, дадлагад, мэргэжлийн анги, ажилтнуудыг оролцуулах ажлыг хийнэ.
7. Мэргэжлийн ангийн бэлэн байдал, багаж хэрэгслийн хангалтанд Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын удирдлагатай хамтран үзлэг хийж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

Зургаа: Хангалт хариуцсан туслахын үүрэг

1. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын дарга, Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн аврах ажилд шаардлагатай багаж, хувцас, техник хэрэгслээр хангах тооцоо хийн удирдлагад танилцуулан шийдвэрлүүлнэ.
2. Шаардлагатай бараа материалын нөөц бүрдүүлэх
3. Гамшгийн голомтод ажиллагсдын хангалтыг зохион байгуулах
4. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, материалын нөөцийг бүрдүүлэх
5. Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хангалтыг зохион байгуулах
6. Гамшгийн уршгаар эвдэрч гэмтсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг засварлах ажлыг зохион байгуулах
7. Үүссэн нөхцөл байдлыг үнэлж, хангалтыг зохион байгуулах талаар саналаа боловсруулж дээд шатны даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

/Монгол улсын засгийн газрын 2000 оны 190 дүгээр тогтоолын хавсралт/

## МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭР ТОДОРХОЙЛОЛТ

4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;

4.1.3.“осол” гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;

4.1.4.“гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;

4.1.5.“аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;

4.1.6.“эмзэг байдал” гэж аюулд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг;

4.1.7.“гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг;

4.1.8.“гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа” гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.9.“гамшгийн зарлан мэдээлэл” гэж олон нийтэд хүргэх дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг;

4.1.10.“эрэн хайх, аврах ажиллагаа” гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг;

4.1.11.“голомтын бүс” гэж гамшиг, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа обьект, нутаг дэвсгэрийг;

4.1.12.“нэрвэгдэгсэд” гэж гамшиг болон аюулд өртсөн иргэдийг;

4.1.13.“гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг;

4.1.14.“гамшгийн хор уршиг” гэж гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн сөрөг үр дагаврыг;

4.1.15.“гамшгийн хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.14-д заасан үр дагаврыг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах, гамшгийг гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг;

4.1.16.“хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа” гэж гамшгийн улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг;

4.1.17.“мэргэжлийн анги” гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг;

4.1.18.“сайн дурын хэсэг” гэж сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг.

БАТЛАВ.

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН ДАРГА
............... /Н.УУГАНБАЯР/

## “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГАЗРЫН 2021 ОНЫ ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Нэг: Зохион байгуулалтын талаар**

| Д/д | Хийгдэх ажлууд | Хугацаа | Хэн гүйцэтгэх |
|---|---|---|---|
| 1 | Танилцуулга шинэчлэх | Тухай бүрд | М.Бат-Эрдэнэ |
| 2 | Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн бүрэлдхүүнийг албаны даргын тушаалаар шинэчлэн тодотгох | Жилдээ | Б.Баярцэцэг |
| 3 | Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулах | Жилдээ | Г.Пүрэвсүрэн |
| 4 | Удирдлага, штабын бүрэлдэхүүн, ажиллагсдын ажлын ба ажлын бус цагаар гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор цуглуулах схем боловсруулах | Жилдээ | Г.Пүрэвсүрэн |
| 5 | Байгууллагын ажиллагсдын гэрийн хаяг, болон утасны бүртгэлд тодотгол хийх | Жилдээ | А.Гэрэлтуяа |

**Хоёр: Сургалт, суртчилгааны талаар**

| Д/д | Хийгдэх ажлууд | Хугацаа | Хэн гүйцэтгэх |
|---|---|---|---|
| 1 | Гамшгаас хамгаалах сургалтыг программын дагуу ажилтан албан хаагчдад заах | Жилдээ | М.Бат-Эрдэнэ |
| 2 | Үйлдвэрийн томоохон осол, байгалийн гэнэтийн болзошгүй аюулын үед хэрхэн ажиллах талаар дадлага сургууль хийх | Жилдээ | |

**Гурав: Холбооны тогтвортой ажиллагааг хангах талаар**

| Д/д | Хийгдэх аж луд | Хугацаа | Хэн гүйцэтгэх |
|---|---|---|---|
| 1 | Штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нөхөн хангах талаар | Улирал бүр | Г.Пүрэвсүрэн |
| 2 | Холбооны хэрэгслийн сэлбэг, материалын аваарын зохих нөөцийг бүрдүүлэх | Жилдээ | Ц.Мөнхдөл |
| 3 | Галын багаж хэрэгслийг нөхөн хангах | Жилдээ | Б.Дорждэрэм |

# ГАМШГИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны дугаар сарын Улаанбаатар хот

Зарлан мэдээллийг штабын бүрэлдэхүүн болон байгууллагын нийт ажилтнуудад хүргэх боломжууд :

Гамшгийн үеийн зарлан мэдээллийг байгууллагын гамшгийн штабын бүрэлдэхүүнүүдэд хүргэхдээ дараах боломжийг ашиглана. Үүнд:

- Суурин утас болон гар утас ашиглана.
- Хөдөлгөөнт холбоог зохион байгуулах
- Холбоочин ашиглаж зар тараах

Нийт ажилчдад: гамшгийн үеийн зарлан мэдээллийг хүргэхдээ дараах боломжуудыг ашиглана. Үүнд:

- Онцгой байдлын газрын дуут дохио
- FM, радиогоор зарлан мэдээлэх
- Телевизийн станцуудыг ашиглах
- Үүрэн телефоныг ашиглах

Дээрх боломжуудыг ашиглан холбоо тогтоох бөгөөд ажиллагсдыг өндөржүүлсэн бэлэн байдалд оруулж, үүрэг даалгавар гүйцэтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг Газрын дарга бөгөөд гамшгаас хамгаалах албаны дарга, штабын дарга нар хамтран зохион байгуулна.

ГАМШГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР Г.ПҮРЭВСҮРЭН

# ГАМШГИЙН ҮЕД АРХИВЫН БАРИМТ БИЧГИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны дугаар сарын Улаанбаатар хот

Ажлын өдөр ажлын цагаар Гамшгийн нөхцөл байдал үүсч архивын өрөө сүйтэж болзошгүй нөхцөл үүссэн үед илрүүлсэн ажилтан Газрын даргад мэдэгдэнэ. Даргын зөвшөөрлөөр байгууллагын Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын зөөх бүлэг архивын баримтыг ач холбогдлын зэргээр *Байнга Хадгалах -70 Жил, Түр хадгалах* гэсэн дараалаар 30-40 минутын дотор аюулгүй газарт шилжүүлнэ. Хэрэв байр тэр чигтээ аюулд өртсөн тохиолдолд Дүүргийн ЗДТГ-ын байрлуу нүүлгэн шилжүүлнэ.

Харин амралтын өдөр болон оройн цагаар гамшгийн нөхцөл үүссэн үед ээлжийн харуулууд Газрын даргад мэдэгдэн Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангиийг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу дуудаж цуглуулан нүүлгэн шилжүүлнэ.

| **Хоёр: Зөөх бүлэг** | | | |
|---|---|---|---|
| Механик | Бүлгийн ахлагч | М.Бат-Эрдэнэ | |
| Нярав | Зөөгч | Б.Дорждэрэм | |
| Нягтлан бодогч | Зөөгч | Ц.Мөнхдөл | |

Нүүлгэн шилжүүлсэн баримтын бүртгэлийг архив хариуцсан ажилтан хариуцна.

АРХИВ БИЧИГ БАРИМТ НҮҮЛГЭН
ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР Г.ПҮРЭВСҮРЭН

# ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ БУС ШТАБЫН БҮТЭЦ



# ГАМШГИЙН ҮЕД ХЭРЭГЛЭХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Бүтээгдэхүүний нэр | Нормоор | Илчлэг | Нэгжийн үнэ, төг | Бүгд үнэ, 1 хоногт- /3*5/ | Хүний тоо | Нийт хүнд ногдох норм /3*7/ | Нийт хүнд ногдох зардлын дүн /6*7/ | 7 хоногт /8*7 хоног/ | 7 хоногт зарцуулах /5*10/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1. | Мах /үхрийн цул / | 0,3 | 321,6 | 8825 | 2648 | 80 | 24 | 211840 | 168 | 1482600 |
| 2. | Гурил | 0,2 | 650 | 891 | 267,3 | 80 | 16 | 21384 | 112 | 99792 |
| 3. | Цөцгийн тос | 0,02 | 149,7 | 2553 | 51,06 | 80 | 1,6 | 204240 | 11,2 | 28594 |
| 4. | Өндөг | 0,1 | 157,2 | 273 | 27,3 | 80 | 8 | 21840 | 56 | 15288 |
| 5. | Талх | 0,05 | 112 | 667 | 33,35 | 80 | 4 | 53360 | 28 | 18676 |
| 6. | Цагаан будаа | 0,03 | 103,2 | 1655 | 49,65 | 80 | 2,4 | 132400 | 16,8 | 27804 |
| 7. | Гурвалжин будаа | 0,005 | 17,1 | 2000 | 10 | 80 | 0,4 | 160000 | 2,8 | 5600 |
| 8. | Ургамлын тос | 0,03 | 162,6 | 1660 | 49,8 | 80 | 2,4 | 132800 | 16,8 | 27888 |
| 9. | Төмс | 0,28 | 175,4 | 1070 | 299,6 | 80 | 22,4 | 85600 | 156,8 | 167776 |
| 10. | Лууван | 0,36 | 56 | 990 | 356,4 | 80 | 28,8 | 79800 | 201,6 | 199584 |
| 11. | Байцаа | | | 1070 | 385,2 | 80 | 28,8 | 85600 | 201,6 | 215712 |
| 12. | Сонгино | | | 989 | 356,04 | 80 | 28,8 | 79120 | 201,6 | 199382 |
| 13. | Амтлагч | 0,002 | | 1300 | 2,6 | 80 | 0,16 | 104000 | 1,12 | 1456 |
| 14. | Цай /ногоон/ | 0,005 | | 3980 | 19,9 | 80 | 0,4 | 318400 | 2,8 | 11144 |
| 15. | Сүү(шинэ сүү) | 0,2 | 134,2 | 1599 | 319,8 | 80 | 16 | 127920 | 112 | 179088 |
| 16. | Иоджуулсан давс | 0,008 | | 500 | 4 | 80 | 0,64 | 40000 | 4,48 | 2240 |
| 17. | Тараг | 0,2 | 134,2 | 1535 | 307 | 80 | 16 | 122800 | 112 | 171920 |
| 18. | Жимс | 0,4 | 187,2 | 3570 | 1428 | 80 | 32 | 285600 | 224 | 799680 |
| | Нийт дүн | | 818 | | **4397** | | | **2266704** | | **3654224** |

## ГАМШГААС ХАМГААЛАХ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ

| Д/д | Албан тушаал | | Овог нэр | Утас | Гэрийн хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн | Томилгоожсон | | | |
| 2 | Төслийн менежер | Штабын дарга | Г.Пүрэвсүрэн | 99116200 | БЗД, 7-р хороо, 31-р байр 122 тоот |
| 3 | Хүний нөөцийн мэргэжилтэн | Байгууллагын тогтвортой үйл ажиллагаа хариуцсан туслах | А.Гэрэлтуяа | 99003335 | БЗД, 5-р хороо, Хаппи таун 73-р байр 154 тоот |
